

## Нэг. ТАНЫ АНХААРАЛД

Ус Цаг Уур, Орчны Судалгаа, Мэдээллийн Хүрээлэн (УЦУОСМХ)-ийн Орчил Урсгал, Урт Хугацааны Прогнозын Судалгааны Хэлтэс (ОУУХПСХ)-ээс 2022 оны 8 – 10 дугаар саруудын урьдчилсан төлөвийг тооцоолон танд хүргэж байна.

Урьдчилсан төлөвийг [Цаг агаар \(tsag-agaar.gov.mn\)](http://tsag-agaar.gov.mn) цахим хуудсанд сар бүрийн 28-нд шинэчлэн гаргадаг тул хэрэглэгч та бүхэн тухай бүрд нь шинэчилсэн мэдээг ашиглаж байна уу.

Дэлхийн Цаг Уурын Байгууллага (ДЦУБ)-аас тогтоосноор олон жилийн дундаж (ОЖД) утга гэдэгт 1991–2020 оны хоорондох тухайн цаг уурын хэмжигдэхүүний дундаж утгыг авч үздэг.

Улирлын төлөвийн талаар лавлах шаардлагатай бол УЦУОСМХ-ийн 11–326606 утсаар холбогдох болон тус хүрээлэнгийн ОУУХПСХ-ээс тодруулах боломжтой.

### Хоёр. ТОЙМ

#### 2.1 8 – 10 дугаар сарын уур амьсгал

Сарын дундаж агаарын температур VIII дугаар сард Алтай, Хангай, Хөвсгөл, Хэнтийн уулархаг нутгаар +8...+12°C, Алтайн өвөр говь болон говь талын нутгаар +20...+24°C, бусад нутгаар +12...+20°C дулаан байдаг бол харин бол IX сард Баян–Өлгий, Хөвсгөлийн ихэнх, Увс, Архангайн баруун, Завханы зүүн, Баянхонгорын хойд, Төвийн зүүн хойд хэсгээр +4...+8°C, Говь-Алтай, Баянхонгор, Өвөрхангай, Дундговийн өмнөд, Өмнөговь баруун болон зүүн, Дорноговийн нутаг, Дорнодын зүүн өмнөд хэсгээр +12... +18°C, бусад нутгаар +8...+12°C дулаан байдаг. X сард Баян–Өлгий, Хөвсгөлийн ихэнх, Увс, Архангайн баруун, Завханы зүүн, Баянхонгорын хойд, Төвийн зүүн хойд хэсгээр 0...-10°C, Говь-Алтай, Баянхонгор, Өвөрхангай, Дундговийн өмнөд, Өмнөговь баруун болон зүүн, Дорноговийн нутаг, Дорнодын зүүн өмнөд хэсгээр +4... +8°C, бусад нутгаар 0...+4°C дулаан байдаг


Хур тунадасны хувьд VIII сард Хангай, Хөвсгөл, Хэнтийн уулархаг нутгаар 60–100 мм, Алтайн өвөр говиор 0–20 мм, бусад нутгаар 20–60 мм бороо ордог бол IX сард Хөвсгөл, Хэнтийн уулархаг нутгаар 25–40мм, Алтайн өвөр говиор 0–5 мм, бусад нутгаар 5–25 мм хур тунадас ордог байна. Харин X сард баруун аймгуудын зүүн хойд хэсэг, төв болон зүүн аймгуудын ихэнх нутгаар 6–15мм, бусад нутгаар 2–5 мм хур тунадас ордог байна.

#### Гурав. 2022 ОНЫ 8 – 10 ДУГААР САРЫН УРЬДЧИЛСАН ТӨЛӨВ


#### 3.1 2022 оны VIII – X сарын цаг агаарын мэдээ

**Наймдугаар сард.** Сарын дундаж агаарын температур ОЖД–аар Баян–Өлгий, Хөвсгөлийн ихэнх нутаг, Ховдын төв, Завханы зүүн, Баянхонгорын хойд, Архангайн баруун, Төвийн зүүн хойд хэсгээр +8...+12°C, Говь–Алтай, Баянхонгор, Өвөрхангай, Дундговь, Дорнодын өмнөд хэсэг болон Өмнөговь, Дорноговийн ихэнх нутгаар +20...+24°C, бусад нутгаар +12...+20°C дулаан байдаг (**Зураг 1а**).

8 дугаар сарын агаарын дундаж температур төв болон говийн аймгуудын ихэнх, зүүн аймгуудын нийт нутгаар ОЖД–аас дулаан байх төлөвтэй байна (**Зураг 1б**).



**Зураг 1а. 8 дугаар сарын агаарын температурын ОЖД (1991-2020)**




**Зураг 1б. 8 дугаар сарын агаарын температурын урьдчилсан төлөв (°C)**

**[Д-агаарын температур ОЖД-аас дулаан]**

Сарын нийлбэр хур тунадас ОЖД–аар Хөвсгөл, Архангай, Булган, Сэлэнгийн нутаг, Төвийн зүүн хойд, Хэнтийн хойд, Дорнодын хойд болон зүүн хэсгээр 60–100 мм, Ховд, Говь–Алтай, Баянхонгорын өмнөд, Өмнөговийн баруун хэсгээр 0–20 мм, бусад нутгаар 20–60 мм хур тунадас ордог (**Зураг 2а**).

8 дугаар сарын нийлбэр хур тунадас Увсын ихэнх, Ховд, Завханы хойд, Хөвсгөлийн баруун хэсгээр ОЖД–аас бага, Өмнөговь, Дорноговь, Сүхбаатарын ихэнх нутаг, Дундговь, Дорнодын зүүн хэсгээр дунджаас ахиу, бусад нутгаар дунжийн орчим орох төлөвтэй байна (**Зураг 2б**).




**Зураг 2а. 8 дугаар сарын хур тунадасны ОЖД (1991-2020)**

**Зураг 2б. 8 дугаар сарын хур тунадасны урьдчилсан төлөв (мм) [Б–хур тунадас ОЖД-аас бага, Н–хур тунадас ОЖД-ийн орчим]**

**Есдүгээр сард.** Сарын дундаж агаарын температур ОЖД–аар Баян–Өлгий, Хөвсгөлийн ихэнх, Увс, Архангайн баруун, Завханы зүүн, Баянхонгорын хойд, Төвийн зүүн хойд хэсгээр +4...+8°C, Говь-Алтай, Баянхонгор, Өвөрхангай, Дундговийн өмнөд, Өмнөговийн баруун болон зүүн, Дорноговийн нутаг, Дорнодын зүүн өмнөд хэсгээр +12... +18°C, бусад нутгаар +8...+12°C дулаан байдаг (**Зураг 3а**).

9 дүгээр сарын агаарын дундаж температур нийт нутгаар ОЖД–ийн орчим байх төлөвтэй байна (**Зураг 3б**).




**Зураг 3а. 9 дүгээр сарын агаарын температурын ОЖД (1991-2020)**

**Зураг 3б. 9 дүгээр сарын агаарын температурын урьдчилсан төлөв (°C) [Н – агаарын температур ОЖД-ийн орчим]**

Сарын нийлбэр хур тунадас ОЖД–аар Хөвсгөл, Архангай, Булган, Сэлэнгийн ихэнх нутаг, Төвийн зүүн хойд, Хэнтийн хойд хэсгээр 25–40 мм, Ховд, Говь-Алтай, Баянхонгорын өмнөд, Өмнөговийн баруун хэсгээр 0–5 мм, бусад нутгаар 5–25 мм хур тунадас ордог байна (**Зураг 4а**).

9 дүгээр сарын нийлбэр хур тунадас нь Баян–Өлгийн ихэнх, Ховд, Хөвсгөлийн баруун, Увсын зүүн, Завханы хойд хэсгээр ОЖД-аас ахиу, бусад нутгаар ОЖД–ийн орчим байх төлөвтэй байна (**Зураг 4б**).




**Зураг 4а. 9 дүгээр сарын хур тунадасны ОЖД (1991-2020)**


**Зураг 4б. 9 дүгээр сарын хур тунадасны урьдчилсан төлөв (мм) [Н-хур тунадас ОЖД-ийн орчим]**

**Аравдугаар сард.** Сарын дундаж агаарын температур ОЖД-аар Баян-Өлгий, Хөвсгөлийн ихэнх, Увс, Архангайн баруун, Завханы зүүн, Баянхонгорын хойд, Төвийн зүүн хойд хэсгээр  $+2...+10^{\circ}\text{C}$ , Говь-Алтай, Баянхонгор, Өвөрхангай, Дундговийн өмнөд, Өмнөговь баруун болон зүүн, Дорноговийн нутаг, Дорнодын зүүн өмнөд хэсгээр  $+6...+8^{\circ}\text{C}$ , бусад нутгаар  $+2...+6^{\circ}\text{C}$  дулаан байдаг (**Зураг 5а**).

10 дугаар сарын агаарын дундаж температур нийт нутгаар ОЖД-ийн орчим байх төлөвтэй байна (**Зураг 5б**).




**Зураг 3а. 10 дугаар сарын агаарын температурын ОЖД (1991-2020)**




**Зураг 3б. 10 дугаар сарын агаарын температурын урьдчилсан төлөв ( $^{\circ}\text{C}$ ) [Н – агаарын температур ОЖД-ийн орчим]**

Сарын нийлбэр хур тунадас ОЖД-аар баруун аймгуудын баруун хойд хэсэг, төв болон зүүн аймгуудын ихэнх нутгаар 6–15 мм, бусад нутгаар 2–5 мм хур тунадас ордог байна (**Зураг 6а**).

9 дүгээр сарын нийлбэр хур тунадас нь Баян-Өлгий ихэнх, Ховд, Хөвсгөлийн баруун, Увсын зүүн, Завханы хойд хэсгээр ОЖД-аас ахиу, бусад нутгаар ОЖД-ийн орчим байх төлөвтэй байна (**Зураг 6б**).



**Зураг 6а. 10 дугаар сарын хур тунадасны ОЖД (1991-2020)**



**Зураг 6б. 10 дугаар сарын хур тунадасны урьдчилсан төлөв (мм) [Н-хур тунадас ОЖД-ийн орчим]**

### 3.2 Зөвлөмж

8 дугаар сард ихэнх нутгаар олон жилийн дунджаас дулаан байх буюу олон хоногоор хэт халуун үргэлжлэх, гэнэтийн аадар бороо орох нөхцөл бүрдэж болзошгүй байна. Иймээс аялал зугаалга, агаар салхинд гарахдаа хугацааны нарийвчилсан мэдээг цаг тухайд нь авч, хэт халалт, гэнэтийн үер усны аюулаас сэрэмжтэй байхыг анхааруулж байна.